

Байгаль хамгаалах ажлын тайланд доор дурьдсан ажлыг тусгалаа.

1.	Танилцуулга	- 2
2.	Тоосго үйлдвэрлэлийн сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	- 5
3.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	- 11
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	- 17
5.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	- 18
6.	Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	- 22
7.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт	- 23
8.	Байгаль орчны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэлт	- 27
9.	Хавсралтууд	- 28
10.	Дүгнэлтүүд	- 48
11.	Төлбөрийн баримтууд	- 63
12.	Шинжилгээнүүд	- 83
13.	Гэрээнүүд	- 88

ТАНИЛЦУУЛГА

Манай “Хуалян” ХХК нь 2004 оноос “Налайхын уурхайн зүүн жигүүр” Шаврын ордод Тоосгоны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна.

Энэ хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүргээ биелүүлэн уурхайн жил бүрийн Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө тайланг гарган мэргэжлийн байгууллагуудаар баталгаажуулан, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголыг хууль дүрмийн дагуу хийлгүүлж Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг эрх бүхий мэргэжлийн компаниудаар боловсруулан тухайн үеийн Байгаль орчны яамаар баталгаажуулан ажиллаж ирлээ.

“Хуалян” ХХК нь “Налайхын уурхайн зүүн жигүүр”-ийн шаврын ордод 2009 онд геологи хайгуулын ажил хийж талбайн нийт шаврын нөөцийг $V=313,644$ мян/м³ бодитой нөөцөөр тооцож эрдэс баялгын мэргэжлийн зөвлөлийн 2010 оны 02 сарын 03-ны өдрийн хуралдаанаар баталгаажуулсан.

Тус шаврын ордыг ашиглах ТЭЗҮ-ийг мэргэжлийн “Аргай-Оч” ХХКомпани хийж гүйцэтгэн Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2018 оны 08 сарын 25-ны өдрийн хуралдаанаар оруулж баталгаажуулсан.

“Аргай-Оч” ХХКомпани 2023 оны 8 сарын 21-ний өдөр ТЭЗҮ-ний нэмэлт тодотгол хийлгэхээр 08/05 гэрээг Ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулсан.

2019 онд “Хуалян” ХХК-ны олборлолт явуулж буй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, сөрөг нөлөөллийг багасгах болон арилгах арга хэмжээ авах зорилгоор БОНБНарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголыг “Мон Слов” ХХК-р хийлгэж 2019 оны 04 сарын 25-ны өдөр БОАЖЯ-ын зөвлөлийн хурлаар батлуулж авсан болно.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий мидлинг хэрэглэхийг хориглох тухай” 62-р тогтоол, Нийслэлийн засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Нам даралтын халаалтын зууханд түүхий мидлинг хэрэглэхийг хориглох тухай” А/1377 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шатаах зууханд мидлинг (5000ккал-с дээш) хэрэглүүлэхийг үүрэг болгосны дагуу 2023 оны 05 сарын 30-ны өдөр “Шинэ Уянга” ХХК-тай 23/20 тоот гэрээг байгуулан мидлинг авч тоосгоо шатаасан болно.

БОАЖЯ болон **УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВ** хамтарсан “Хариуцлагатай уул уурхай. Орчны шинжилгээ. Нөхөн сэргээлт ” сургалтанд төлбөр 1000000 төгрөгийг төлж 2 хүн оролцсон.

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА-р 2023 оны 04 сарын 10-ны өдөр ХУД 23/66 тоот хаягдал усны дүгнэлтийг гаргуулан авч мөрдлөг болгон ажилласан.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР-р 2023 оны 04 сарын 18-ны өдөр 23/18 тоот Ус ашиглах дүгнэлтийг гаргуулан авч мөрдлөг болгон ажилласан.

“ **Молор дэлбээлэх нахиа**” **ХХК-с 2023 оны 06 сарын 16-ны өдөр 50ш харгана 50ш хайлаас модны суулгац** авч тарьсан.

2023 онд ажиллах хүчний дутагдал болон тоосгоны борлуулалт муу байснаас төлөвлөгөөний дагуу олборлолт хийж үйлдвэрлэлт явуулж чадсангүй .
1000000 ш тоосго үйлдвэрлэж 721714 ш тоосгыг өртөгийн үнээр борлуулж ашигтай ажиллаж чадаагүй болно.

Тоосго үйлдвэрлэлийн явцад хүний болгоомжгүй үйл ажиллагаанаас шатах тослох материал, шингэн хаягдал хөрсөнд нэвчиж бохирдуулсан тохиолдол гаргахгүй ажилласан.

БОНБайдлын нарийвчилсан үнэлгээнд байгаа зөвлөмж, менежментийн төлөвлөгөө хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу тухайн жилд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хийх ажлын төлөвлөгөөг гарган төсөв боловсруулан үйлдвэрийн жилийн санхүүгийн тооцоонд оруулж батлуулж **26 206 200** төгрөг зарцуулав.

2023 онд Байгаль орчин хамгаалахад шаардагдах зардлыг төлөвлөх, сөрөг нөлөөллийг бууруулах талаар зөвлөмж боловсруулан төслийг хэрэгжүүлсэн явцад мөрдөж ажиллах оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж **БОАЖЯ**маар баталгаажуулахаар өгөхөөр бэлтгэж байна.

“Хуалян” ХХК-ийн уурхайн ерөнхий мэдээлэл

Үзүүлэлтүүд		
Аж ахуйн нэгжийн нэр		“Хуалян” ХХК
Улсын бүртгэлийн дугаар		9019047059
Уурхайн нэр		“Налайхын уурхайн зүүн жигүүр”
Ордын нэр		Шаврын орд
Ордын байршил	Нийслэл/ Хот/ Аймаг	Улаанбаатар
	Сум/Дүүрэг	Налайх
Ашигт малтмалын төрөл		Шавар
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		4508А
Ашиглалтэхэлсэногноо		2004 он
Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
	Сум/Дүүрэг	Налайх
	Баг/Хороо	3-р хороо
	Гудамж/Байр	“Хуалян” Тоосгоны үйлдвэр
	Гарутас	80446604, 99883294
		88160765
	Электроншуудан	khualyan@gmail.com
	Вэбхуудас	-
Захирлынхаяг	Нэр	Ш. Оюунгэрэл
	Утас	89695569
	Факс	366744
	Гарутас	99115569
	Электроншуудан	sh_oyun1961@yahoo.com
ТЭЗҮ хийсэн огноо		2018 оны 08 сарын 15
Ашиглах хугацаа		58 жил
Жилийн хүчин чадал		Жилд 3.0 сая ширхэг тоосго үйлдвэрлэх
Урьд онуудад олборлосон нийт бүтээгдэхүүний хэмжээ		37.7 сая ш тоосго
Тухайн онд гаргасан бүтээгдэхүүний хэмжээ		1,0 сая ш\тоосго

ТЕХНОЛОГИЙН ДАРААЛАЛ

Ордоос ил аргаар шаврыг олборлон бульдозероор түрж овоолго үүсгэсэн ба хувиарлагч бункерээр дамжуулан чулууг ялгах шигшүүрт өгнө.

Ялгалтаар цэвэр шавар гарах бөгөөд үүнийг үйлдвэрлэлийн туузан зөөгүүрээр дамжуулан бутлах 1-р тээрэмд хүргэнэ. 1-р тээрмээр бутлагдсан шаврыг мөн 2-р тээрэмд туузан дамжуулагчаар дамжуулна. 2-р тээрмээс гарсан шавар нь зуурагч машинд орох ба тогтсон хэмжээний чийглэгт хүргэн усыг хольж жигд хутган зуурмагыг бэлтгэнэ. Бэлэн болсон зуурмаг туузан дамжуулагчаар дамжин сорох вакум бүхий шахах прест орно. Нягтруулан шахсан шавар нь хэвлэх хошуугаар дамжин таслагчид очно. Стандартын хэмжээгээр таслагдсан түүхий тоосгыг зөөгч бага оврын машинаар зөөж хатаах талбайд хүргэнэ. Хатаах талбайд хатсан тоосгыг шатаах баюунд оруулж шатаана. Бэлэн болсон тоосгыг борлуулалтын талбайд зөөж хураана.

1. ШАВАР ОЛБОРЛОЛТ БОЛОН ТООСГО ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Шавар олборлолтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болох юм. Мөн хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэх шинж чанартай байна. Нүдэнд үл үзэгдэхээс үзэгдэх, усанд үл нордогоос нордог хүртэлх хэмжээтэй тоос агаар, ургамлан нөмрөг, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө. Төслийн талбай болон түүний ойр орчимд тархах магадлалтай. Шатаах зууханд чанар сайтай мидлинг хэрэглэхгүй бол шаталт муугаас болон шатаах зуухны яндангийн шүүр муудсанаас утаа тортогтой гарч агаар чанарт нөлөөлнө. Уурхайд ашиглагдаж буй хүнд машин механизмаас ялгарах утаа хий нь агаарын бохирдлын эх үүсвэр болно.

Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх нөлөөлөл

Шавар олборлолтын үйл ажиллагааны үед хөрс хуулалт их хэмжээгээр явагдаж, газрын хэвлийд хонхор үүсэн гүнээс гарах их хэмжээний хөрсний овоолго газрын хэвлий дээр бий болон газрын ландшафтад өөрчлөлт бий болно. Мөн шатах, тослох материал хөрсөнд нэвчиж хөрсний чанарыг муутгадаг.

Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

Тоосгоны үйлдвэрлэлийн усны хэрэгцээг Гүний худгаас хангадаг. Ил уурхайгаас нилээд хэмжээний шүүрлийн ус ялгардаг. Хог хаягдал, бохир усыг зөвшөөрөлгүй хаях, шатах тослох материалын асгаралтын улмаас хөрсний бохирдол үүсч, цаашдаа газрын доорхи усанд нөлөөлж болзошгүй.

Ургамал ба амьтанд үзүүлэх нөлөөлөл

Шавар олборлолтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас ургамлын нөмрөг устаж, тус газарт нутагшсан амьтад амьдрах орчноо алдана. Ургамлан нөмрөг их хэмжээгээр устсанаас тухайн орчны агаарт өөрчлөлт орж, хуурайшилт бий болно. Уурхайн эдэлбэр газар, дэд бүтцийн зарим талбайн ургамал, амьтан өртөх магадлалтай.

Хог хаягдлын нөлөөлөл

Ажлын байрнаас хатуу (ахуйн хог хаягдал, хаягдал мод, төмөр, хуучин дугуй, сэлбэг), шингэн (ахуйн бохир ус, ашигласан тос, түлш шатахууны хаягдал) хог хаягдал гарна. Хатуу, шингэн хог хаягдал хөрсөнд ил задгай хаягдсанаас орчны хөрсийг, гүний усыг бохирдуулах боломжтой. Тухайн газрын хөрс, ургамал, амьтан нөлөөлөлд хамгийн түрүүнд өртөх магадлалтай. Аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан, Ахуйн хаягдал болон үйлдвэрээс гарах бохир усыг хяналтгүй хаясны улмаас орчны хөрс, газрын доорхи ус, ургамалжилтанд дам нөлөөлнө.

ОРДЫН ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХТАЙ ХОЛБОГДСОН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Шавар олборлолтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болдог тул хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэдэг учир хуурайшилт ихтэй улиралд зам талбайг тогтмол услан зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт явуулж, олон салаа зам гаргахгүй байх тал дээр анхааран ажиллаж байна.

Шатаах зууханд чанар сайтаймидлинг хэрэглэж, шатаах зуухны яндангийн шүүрийг цаг тухайд нь сольж байсан. Уурхайд ашиглагдаж буй хүнд машин механизмаас ялгарах утаа хий нь агаарын бохирдлын эх үүсвэр болдог тул техникийн үзлэгт оруулсан, ялгаруулж буй хорт утаа нь стандартын түвшинд буй машин техникийг ашиглах, ашиглагдаж буй машин техникт үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийх, яндан бүрт шүүлтүүр суурилуулж өгөх, тохиргоо техникийн горимыг сайтар мөрдөх, түлшний найрлага, чанар, стандартыг сайтар хянах, чанартай түлш хэрэглэх зэрэг арга хэмжээ авч байна.

Агаарын бохирдлыг багасгахын тулд хийсэн ажлууд

1. Шатаах зууханд чанарын шаардлага хангасан мидлингийг “Шинэ Уянга” ХХК-тай гэрээ хийж авч хэрэглэв.
2. Зуухнаас гарч байгаа утаа нь сайн чанарын мидлинг хэрэглэснээс хэвийн гарч байсан.
3. Шатаах зуухны утааны тоосролтыг багасгах шүүлтүүрийг үйлдвэрлэлийн явцад 3 удаа сольж тавьсан нь дотор нь ажиллах нөхцөлийг сайжруулж байсан.
4. Мидлингийг шатаах зуухны хажууд буулгаж овоолго үүсгэн тусгай зориулалтын полиэтилен цаасаар битүү хучиж хадгалж хэрэглэж байна. Энэ нь нэг талд байгаль орчныг бохирдуулахгүйгээс гадна орчны ариун цэврийн байдлыг

хангаж, ажилчдын эрүүл мэндэд сайн нөлөө үзүүлсэн ажил болсон байна.

5. Хэрэглэгдэх шатах тослох материалыг Магнай трейд, Петровис компаниудаас авч ашиглаж, стандартын шаардлагын дагуу хадгалж ашигласан болно.
6. Ажиллагсдад үйлдвэрлэлийн ажил эхлэхийн өмнө агаарын бохирдол, хөрс ургамал, хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх , түүнийг бага байлгах арга боломжийн талаар сургалт хийсэн болно.
7. Ажиллагсдыг тоосжилтоос хамгаалах зорилгоор амны хаалт олгож байв.
8. Үйлдвэрлэлийн талбайд хог хаягдлын сав байрлуулсан бөгөөд хатуу хог хаягдлыг 7 хоног бүр Дүүргийн төвлөрсөн хог хаягдлын цэгт зайлуулж байв.
9. Шатаах зуухны дотор термометр тавьж доторх температурт хяналт тавьж ажилласан.
10. Агаар дахь тоосжилтыг Цаг уур. Орчны Шинжилгээний Газар Байгаль Орчин Хэмжил зүйн төв лабораторид хүсэлт гарган шинжлүүлсэн болно.

Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Үржил шимт хөрсийг хуулан овоолго үүсгэн технологийн дагуу хадгалж, нөхөн сэргээлтэнд эргүүлэн ашиглаж эргэлтэнд оруулж байна. Хөрсний элэгдэл, эвдрэлийг нэмэгдүүлэхгүйн тулд зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт явуулна. Автомашины зогсоолын талбайг тэгшлэн шатах, тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх; Машин техникийн хөдөлгөөнөөр босох тоосны хэмжээг хамгийн бага түвшинд барихын тулд хучилтгүй замын гадаргууг засварлах, замыг услах, зөвшөөрөлтэй талбайд байгаа ашиглагдахаа больсон хуучин замуудыг нөхөн сэргээх ажил хийсэн.

Хөрсний бохирдлыг багасгах талаар хийсэн ажлууд

1. Тус шаврын ордыг 2004 оноос хойш ашигласан бөгөөд өнөөдрийг хүртэл тэр ухлага хийсэн талбайг өргөтгөх замаар олборлолт явуулж байсан **2700м²** буюу

0.27 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж биологийн нөхөн сэргээлтээр “Молор дэлбээлэх нахиа” ХХК-с 2023 оны 06 сарын 16-ны өдөр 50ш харгана 50ш хайлаас модны суулгац авч тарьсан.

2. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээг Налайх дүүргийн “ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-тай 2023 оны 04 сарын 02-ны өдөр гэрээ байгуулан мөрдөж ажилласан.
3. Олборлолтыг нөхөн сэргээлт хийхэд боломжтой байдал, шаврын зузаанаас хамаарч явуулсан.
4. Үйлдвэрлэлийн талбайд тэмдэгшүүлэлтийг сайн хийж, ялангуяа тээврийн хэрэгсэл зорчих замыг тодорхой болгож тэмдэгшүүлсэн.
5. Шаврын нөөцийг нь авсан гүехэн газруудыг чулуулгаар дүүргэлт хийж мөргөцөгийн хажууг налуулалт хийж хөрсний нөхөн сэргээлт хийсэн болно.
6. Шавар намагтай газрыг хайрга асгаж янзалсан.
7. Ажилчдын байр болон конторын урьд талбайд тоосгоор хучилт хийж шалбааг үүсэхээс сэргийлсэн.
8. Ордын орчимд мидлингний уурхайн олборлолт хийсэн Налайх дүүргийн иргэдэд нөхөн сэргээлт хийлгэх талаар шаардах бичиг өгсөн боловч орхисон байсныг өөрийн техникийг ашиглан эргүүлж булах ажил зохион байгуулсан.
9. Бохирдсон хөрсийг хуулан авч хогийн цэгт хаясан.
10. Үйлдвэрлэлийн ажил эхлэхийн өмнө хийсэн сургалтаар ажилчдад хөрсийг бохирдуулах нь ямар хор нөлөөтэй болох талаар хичээл заасан.
11. Хөрсний шинжилгээг Цаг уур. Орчны Шинжилгээний Газар Байгаль Орчин Хэмжил зүйн төв лабораторид хүсэлт гарган шинжлүүлсэн болно.

Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Усны цогц бодлогын дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж, усны хэрэглээг хамгийн бага түвшинд байлгах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд усны эх үүсвэрүүдэд эрүүл ахуйн болон хамгааллын бүс тогтоож, холбогдох дэглэмийг мөрдөн ажиллаж байна. Усыг тоос дарах зорилгоор ашигладаг. Хог хаягдал, бохир усыг зөвшөөрөгдсөн талбай нүхэнд хийж, шатах тослох материалын асгаралт гаргаж хөрсний бохирдолгүй ажилласан нь гүний усанд нөлөөлөх нөлөөлөлгүй ажилласан болно.

Усны бохирдлыг багасгахын тулд хийсэн ажлууд

1. MNS900:2005 –н шаарлага хангаж байгаа тул өөрийн гүний худгаас авч хэрэглэж байна.
2. Хөрсөн дээр бохирдол үүсгэхгүй ажиллах талаар ажил эхлэхийн өмнө ажилчдад Хийсэн сургалтаар тайлбарлан ойлгуулж техник эзэмшигч ажилчдаар гарынүсэг Зуруулж баримтжуулж авсан.
3. Үйлдвэрийн орчны хог хаягдыг бороо үерийн усаар дамжин орж ирэхээс болгоомжилж цэвэрлэж байсан.
4. Үйлвэрлэл ахуйн зориулалттай усыг өөрийн худгаас ханган ажилласан.
5. **ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА-р 2023 оны 04 сарын 10-ны өдөр ХУД 23/66 тоот хаягдал усны дүгнэлтийг** гаргуулан авч мөрдлөг болгон ажилласан.
6. **НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ БОГ-р 2023 оны 04 сарын 18-ны өдөр 23/18 тоот Ус ашиглах дүгнэлтийг** гаргуулан авч мөрдлөг болгон ажилласан.
7. Налайх дүүрэгтэй Ус ашиглах гэрээг 2023 оны 05 сарын 10-ны өдөр байгуулсан.
8. Налайх дүүрэгтэй Ус бохирдуулсаны төлбөрийн гэрээг 2023 оны 05 сарын 15-ны өдөр байгуулж төлбөр төлсөн болно.
9. Усны шинжилгээг Цаг уур. Орчны Шинжилгээний Газар Байгаль Орчин Хэмжил зүйн төв лабораторид хүсэлт гарган шинжлүүлсэн болно.

Ургамал ба амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээнд

Өнгөн хөрсийг хуулах үед тухайн газрын ургамлан нөмрөг, шавьж, жижиг мэрэгчид зэрэг амьтад үгүй болсон байна. Ургамлан нөмрөг их хэмжээгээр устсанаас тухайн орчны агаарт өөрчлөлт орж, хуурайшилт бий болдог тул уурхайн явцын техникийн нөхөн сэргээлтийг хийж, биологийн нөхөн сэргээлтийг ажилд талбайг хамруулан хийсэн. Хуулж авсан өнгөн хөрсийг стандартын дагуу овоолго хийн хэлбэржүүлэн хадгалж, явцын нөхөн сэргээлтэнд хэрэглэж байна.

“Молор дэлбээлэх нахиа” ХХК-с 2023 оны 06 сарын 16-ны өдөр 50ш харгана 50ш хайлаас модны суулгац авч тарьсан.

Карьерт хүн, мал, ан амьтан унахаас сэргийлэх арга хэмжээнд тэмдэг тэмдэглэгээ хийсэн.

Үйлдвэрлэлийн нөхөн сэргээлтийн ажлыг үйлдвэрлэл байрлах Налайх дүүргийн 3-р хорооноос сонгосон иргэдийн төлөөлөл 3 хүнийг 2023 оны 09 сарын 05-ны өдөр үйлдвэр дээр авчирч үзүүлж, танилцуулан дүгнүүлж ажиллалаа.

Хог хаягдлын нөлөөлөлийг бууруулах арга хэмжээнд

Ахуйн хаягдал болон үйлдвэрээс гарах бохир усыг хяналтгүй хаясны улмаас орчны хөрс, газрын доорхи ус, ургамалжилтанд дам нөлөөлдөг тул, аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлж байна.

Налайх дүүргийн “ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-тай 2023 оны 04 сарын 02-ны өдөр гэрээ байгуулан 594000 төгрөгийг төлж, Бохир ус зайлуулах гэрээг “Чандмань Налайх” ХХК-тай байгуулан 198200 төгрөгийн төлбөрийг төлж ажилласан.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүсэх байгаль орчны зөрчлийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯамаар батлуулж мөрдөж ажиллаж байна. Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан Уул уурхайн аврах албаар батлуулан хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

3.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус шаврын ордыг 2004 оноос хойш ашигласан ухлага хийсэн талбайг өргөтгөх замаар олборлолт явуулж байсан бөгөөд 2023 он хүртэлх Уурхайн ашиглагдсан орон зайг нийт 0.27 га талбайд налуулан хэвгийжүүлж ойролцоогоор 200 м урттай 2 шатлалтай 13,5 м өргөнтэй мөргөцөг үүсгэн, **2700 м²** буюу **0.27 га** техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 2023 оны 07 сарын 31-нээс 8 сарын 30-ны өдөр хүртэл 380 ресс нийт 3360 м² шороогоор дүүргэлт хийж гүйцэтгэсэн байна.

Эвдэрсэн газар, хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу нөхөн сэргэсэн болно. Үржил шимт хөрсийг хуулан овоолго үүсгэн технологийн дагуу хадгалж, нөхөн сэргээлтэнд эргүүлэн ашиглаж эргэлтэнд оруулж байна. Хөрсний элэгдэл, эвдрэлийг нэмэгдүүлэхгүйн тулд зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт явуулж хэвшлээ.

Нөхөн сэргээлтэнд нийт **20810000** төгрөг зарцуулав.

Байгаль орчин хамгаалах зардалд нийт **26206200** төгрөг зарцуулав.

Техникийн болон Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг “**ООБОО**” ХХК-р хэмжилт хийлгэж талбайн хэмжээг баталгаажуулан гаргав.

Нөхөн сэргээлтийг фотожуулж зардлын баримтыг хуулбарлан тайланд хавсаргав.

Нөхөн сэргээлтэнд оролцсон ажилчдын цалин

Д/д	Огноо	Ажилтаны овог нэр	Гүйцэтгэсэн ажил	Хүн / өдөр	Цалин
1.	7/31	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
2	8/1	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
3	8/2	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
4	8/3	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000

5	8/4	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
6	8/5	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
7	8/6	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
8	8/7	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
9	8/8	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
10	8/9	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
11	8/10	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
12	8/11	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
13	8/12	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
14	8/13	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
15	8/14	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
16	8/15	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000

17	8/16	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
18	8/17	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
19	8/18	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
20	8/19	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
21	8/20	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
22	8/21	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
23	8/22	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
24	8/23	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
25	8/24	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
26	8/25	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
27	8/26	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
28	8/27	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000

29	8/28	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
30	8/29	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
31	8/30	Лхагвасүрэн Баасансүрэн	Дугуйт ачигч оператор болон өөрөө буулгагчийн жолооч	1	60000
		Доржсүрэн Цагаанаа	Эксковаторч	1	60000
		Нийт цалин		62	3720000

Тооцоолсон нягтлан бодогч
Хянасан захирал

Б. Даваасүрэн
Ш.Оюунгэрэл

Техникийн нөхөн сэргээлтэнд гарсан шатахууны зардал

д/д	Огноо	Харилцагчийн нэр	Татвар төлөгчийн дугаар	НӨАТ төг	НӨАТ төг
1.	2023.07.31	НИК ХХК	2075261	481818,18	5300000
2.	2023.08.13	Синчи-Ойл ХХК	2588617	115468,18	1270150
3.	2023.07.31	НИК ХХК	2075261	469090,91	5160000
		Бүгд			11730150

Техникийн нөхөн сэргээлтэнд гарсан зардал

д/д	Гарсан зардлууд	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг
1	Ажилчдын цалин	Хүн/өдөр	62	60.0	3720.0
2.	Шатахууны зардал	л	3910	3000	11730.1
3.	Тээврийн зардалд	ресс	380	12000	4560.0
4.	“ООБОО” ХХК-д зургийн ажилд				300.0
	Бүгд				20310.1

Биологийн нөхөн сэргээлтэнд гарсан зардал

д/д	Гарсан зардлууд	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг
1	Ажилчдын цалин	Хүн/өдөр	10	30.0	300.0
	Модны суулгац				
	Харгана	ш	50	2000	100.0
	Хайлаас	ш	50	2000	100.0
	Бүгд				500.0

Нөхөн сэргээлтийн нийт зардал 20 810 000 төгрөг болов.

Тооцоолсон нягтлан бодогч
Хянасан захирал

Б. Даваасүрэн
Ш.Оюунгэрэл

4.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	Нийт Зардал төгрөг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримталсан Эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлыг цэгт байгаа хаягдлыг төвлөрсөн цэг рүү зөөвөрлөсөн.	Хог хаягдлын цэг		Байгаа хог хаягдал		594000 төгрөг төлсөн	Байгаль орчны баг	Байхгүй	Гэрээний дагуу хийгдсэн	Компаний дотоод журам, Хог хаягдлын тухай хууль 2004
Технологийн хог хаягдлыг дахин бутлаж үйлдвэрлэлтэнд ашигласан	Технологийн хаягдал Цагаан тоосго		Тухайн оны хуримтлагдсан хаягдал		Үйл ажиллагааны зардал	Технологи инженер	Байгаль орчны баг	Хуримтлагдсан цагаан тоосго	Компаний дотоод журам, технологийн заавар
Бохирдсон хөрс шороонд бохирдлын хэмжээг лабораторийн аргаар тодорхойлуулсан	Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хэсэгт		Бохирдсон хөрс шороо		158000 төгрөг төлсөн	Байгаль орчны баг	Байгаль Орчны Судалгаа Шинжилгээний Төв УТҮГ газарт	Энэ жилийн бохирдсон хэмжээ	MNS 5850:2008 – хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Ажилчдын байрны бохирын шугам хоолойг шинэчилсэн	Ажилчдын байр		Ажилчдын байрнаас гарах бохирдол		198200 төгрөг төлсөн.	Үйлдвэрийн захиргаа	Чандмань Налайх ОНӨААТҮГ	Ажилчдын байрны орчимд цэвэр болгов.	Хаягдал ус зайлуулах цэг сонгох журам. БО-ны сайдын тушаал 167/335/а/171, 1995
Нийт дүн					950200				

Төлбөр төлсөн баримтуудыг хуулбарлан тайланд хавсаргасан .

5.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Техник технологийн зохион байгуулалтын арга хэмжээ	Гүйцэт гэх хугацаа	Хяналт тавих тайлагнах мэдээллэх	Баримталсан эрх зүйн баримт бичиг
Байгаль орчныг хамгаалах сөрөг нөлөөллийг бууруулж нөхөн сэргээх ажлыг менежментийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн.	Жилийн туршид	Хуалян ХХК-ний захиргаа	БОНБУ-ний тухай хууль
БОНБайдлын нарийвчилсан үнэлгээнд байгаа зөвлөмж, менежментийн төлөвлөгөө хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу тухайн жилд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хийх ажлын төлөвлөгөөг гарган төсөв боловсруулан үйлдвэрийн жилийн санхүүгийн тооцоонд оруулж батлуулж 26 206 200 төгрөг зарцуулав.	Жилийн туршид	Хуалян ХХК-ний захиргаа	MNS 5917 : 2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
Тоосгоны үйлдвэр, шаврын карьерт ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслэлээр хангаж, аюулгүй ажиллах дүрэм журамд сургаж, сургалт зохион байгуулж, тэдний	Төлөвлөгөөний дагуу хийгдэв	ХХАА инженер Ш. Давааням БОХариуцсан ажилтан Н. Отгондорж	Агаарын бохирдлыг бууруулах бууруулах тухай 2011

<p>эрүүл мэндэд хяналт тавьж, илчлэг хоол хүнсээр хангаж ажиллагсдын амьдрах орчны цэвэрлэгээг байнга тогтмолжуулж тоосжилтыг багасгаж ажилласан.</p>			
<p>Дүүрэг нийслэл улсын чанартай байгаль хамгаалах сургалт семинарт Байгаль орчин хариуцсан ажилтаныг оролцуулж байна.</p>	<p>БОАЖЯ болон УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВ хамтарсан “Хариуцлагатай уул уурхай нөхөн сэргээлт, Орчны хяналт шинжилгээ” сургалтанд төлбөр төлж 2 хүн оролцсон.</p>	<p>Захирал Ш. Оюунгэрэл О. Сүхбаатар</p>	<p>БОНБУ-ний тухай хууль</p>
<p>Ажиллагсдыг байгаль орчин хамгаалах сөрөг нөлөөлөл багатай үйл ажиллагаа явуулах сургалтанд хамруулсан.</p>	<p>Үйлдвэрлэл эхлэхийн өмнө зохион байгуулсан.</p>	<p>Н. Отгондорж</p>	<p>Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995</p>
<p>Үйлдвэрийн орчны тоосжилт, агаар, дуу чимээ, ус, хөрсний шинжилгээг Байгаль Орчны</p>	<p>06 сард</p>	<p>Менежер О. Сүхбаатар</p>	<p>MNS 5885 : 2008 Агаарт байх бохирдуулах</p>

<p>Хэмжил Зүйн Төвд хүсэлт гаргаж шинжлүүлж хяналт тавин ажиллаа.</p>			<p>бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 900:2005- Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 5850:2008 – хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ</p>
<p>Нөхөн сэргээлт хийсэн ажлаа 10 сард Нийслэлийн МХГ-т шалгуулахаар хүсэлт гаргасан боловч , 2023 оны 10 сарын 31-ний өдөр Нийслэлийн БОГазарт нөхөн сэргээлтийн ажлаа шалгуулахаар албан бичиг өгөөд байна.</p>	<p>10сарын 31</p>	<p>Хуалян ХХК-ний захиргаа</p>	<p>БОНБУ-ний тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995</p>
<p>Нийслэлийн БОГ-т хандаж нөхөн сэргээлтийн ажлаа шалгуулахаар хүлээж байна.</p>		<p>Менежер О. Сүхбаатар</p>	<p>БОНХөгжлийн Сайдын 2014 оны 01</p>

			дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаал
Байгаль орчны менежментийн тухайн жилийн ажлын тайлан мэдээг БОАЖЯ, НБОГ-т хүргүүлж байна.	10сарын 31	Менежер О. Сүхбаатар	Ашигт малтмалын тухай хууль 2006 Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995

6. БОМТ-г ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Оролцогч талууд	Тайлангийн агуулга хэлэлцүүлэх хэлбэр	Гүйцэтгэх хугацаа	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулсан газар
Налайх дүүргийн 3-р хорооны иргэд Ц. Алтанцэцэг Б. Тамирбаяр Г.Отгонбаяр Ч. Байгалмаа	БОМТөлөвлөгөөр хэрэгжүүлсэн ажлаа тайлагнав.	2023 оны 9 сарын 05-ны өдөр	Байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг буруулах талаарх санал авсан.	Үйлдвэр дээр авчирч үзүүлж дүгнүүлсэн.
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчид	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон 2023 оны нөхөн сэргээлт хийсэн ажлаа танилцуулсан.	2023 оны 10 сарын 25-ны өдөр	Байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг буруулах талаарх шинэлэг зөвөлгөө авсан.	Үйлдвэр дээр
Нийслэлийн БОНХГ	БОМТ-ны гүйцэтгэсэн ажлын тайланг Хянуулж дүгнэлт гаргуулах	2023 оны 11 сард	Хэрэгжүүлсэн ажилд хяналт тавьж үнэлгээ дүгнэлт өгөх	Үйлдвэрлэлийн Олборлолтын болон нөхөн сэргээлт хийсэн талбайд
БОАЖЯ	Гүйцэтгэсэн ажлын тайланг хянуулж төлөвлөгөөг батлуулах	2023 оны 12 сард	БОМТ-ны хийгдэж ажилд зөвөлгөө, үнэлгээ авах	БОАЖЯ

Иргэдийн үнэмлэхний хуулбар хавсаргав.

7. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийг хэрэгжүүлсэн явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тухайн орчинд зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, холбогдон гарах зарим зардлуудын хамт тодорхойлж ирсэн.

Төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах ОХШХ нь тус төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичгийн нэг юм.

Төслийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явцад хяналт шинжилгээний ажлыг энд тусгасан хугацаа болон аргачлалын дагуу үргэлжлүүлэн хийх нь тухайн төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шуурхай тогтоохоос гадна түүний олон жилийн судалгааны мэдээ материал нь нутгийн хөрс, ургамал, гадаргын ба газрын доорх ус зэрэг экосистемийн бүрдэл хэсгүүдийн хоорондын харилцан шүтэлцээг тодорхойлж, тэдгээрийн талаарх шинжлэх ухааны мэдлэгийг бий болгох чухал хэрэглэгдэхүүн болно.

Жил бүр хийгдсэн хяналт, шинжилгээний үзүүлэлтүүдийг анхааралтай судалж үзэж байх нь цаашдаа байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт оршин суугчдыг төслийн нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүүүндэслэлтэй болгох юм. Нөгөө талаас ОХШХ-г улам боловсронгуй болгох хяналт, шинжилгээ хийж байгаа объектоо бүрэн хамарч байгаа эсэхийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.

Улаанбаатар хот орчмын газар нутаг нь хөрс газарзүйн Хангайн их мужийн Хангайн төвийн районы баруун өмнө захын хэсэгт хамаарагдана. Энд уулын хар хүрэн, хүрэн, нугын хүрэн, хээрийн хүрэн хөрс тус тус тархах бөгөөд хээрийн хүрэн хөрс зохилох байр суурийг эзэлж байна. Тоосгоны үйлдвэр, шаврын ордын орчмоор хээрийн хүрэн хөрс тархсан байна.

АГААРЫН БОХИРДОЛТЫГ БУУРУУЛАХАД ХИЙХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал мян.төг	Хариуцсан эзэн	Баримталсан эрх зүйн баримт бичиг
1.	Зам талбайг тэгшлэх, услах, ургамалжуулах, замын тоосжилтыг багасгах	Төслийн хугацаанд	БОНБНУ нэлгээнд заасан дагуу	Менежер О. Сүхбаатар	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага
2	Ажиллагсдад агаарын бохирдол, хөрс ургамал, хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх, түүнийг бага байлгах арга боломжийн талаар сургалт хийсэн болно.	Ажил эхлэхийн өмнө		БОХ ажилтан Н. Отгондорж	БОНБНУ-ний тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995
3	Тоос шороотой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдад нормын сүү, цагаан идээгээр хангах	Төсөл хэрэгжих хугацаанд	120 хоногт 4хүнд 960.0	Менежер О. Сүхбаатар	Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль 2006
4	Мидлингийг хучиж хадгалах полиэтилен худалдаж авахад	Хяналт тавин ажиллах	340.0	Менежер О. Сүхбаатар	Агаарын бохирдлыг бууруулах тухай хууль 2011
	Нийт зардал		1300.0		

ХӨРСНИЙ БОХИРДОЛТЫГ БУУРУУЛАХАД ХИЙХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал мян.төг	Хариуцсан эзэн	Баримталсан эрх зүйн баримт бичиг
1.	Уурхайн эдэлбэр газрын хил хязгаарын тэмдэгжүүлэлтийг сайжруулах, олон салаа зам гаргахгүй байхад	он	100.0	Менежер О. Сүхбаатар	Газрын тухай хууль 2002
2.	Карьерт хүн, мал, ан амьтан унахаас сэргийлэх арга хэмжээнд тэмдэг тэмдэглэгээ хийсэн	он	100.0	Менежер О. Сүхбаатар	Газрын тухай хууль 2002
	ДҮН		200.0		

УСАН ОРЧНЫ БОХИРДОЛТ БУУРУУЛАХАД ХИЙХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал мян.төг	Хариуцсан эзэн	Баримталсан эрх зүйн баримт бичиг
1.	Уурхай дотор болон уурхайн орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байх (урьдчилан сэргийлэх арга хэмжээнд)	Тоосго шатаах явцад	Дотоод зардлаар	Механик инженер Ш. Давааням	Усны тухай хууль MNS 5850:2008 – хөрсний чанар. Хөрсбохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2.	Тоосжилтыг дарах зорилгоор автозам, уурхайн карьерийн мөргөцөг, шинэ овоолгын тоосжилтоос хамгаалах усалгаа хийж байсан ажилчны цалинд	Тоосго шатаах явцад	400.0	Гүйцэтгэх захирал Б. Хасбаатар	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага
	Дүн		400.0		

2023 онд БОМТ хэрэгжүүлэхэд хийгдсэн ажил, зардал

	Хийгдсэн ажлууд	Зардал / төг /	Хариуцсан ажилтан
1.	Нөхөн сэргээлтийн ажил	20810000	Б. Хасбаатар
2.	Агаарын бохирдол бууруулахад	1300000	О. Сүхбаатар
3.	Хөрсний бохирдол бууруулахад	200000	Ш. Давааням
4.	Усны бохирдол бууруулахад	400000	Н. Отгондорж
5.	Хог хаягдал менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд	950200	Б. Хасбаатар
6.	Хариуцлагатай уул уурхай, орчны шинжилгээ, нөхөн сэргээлт сургалтанд	1000000	Ш. Оюунгэрэл
7.	Байгаль орчны нөхөн сэргээх баталгаа төлбөр	1546000	
	ДҮН	26206200	

Байгаль орчин хамгаалах зардалд нийт 26206.2 мянган төгрөг зарцуулсан болно.

Тооцоолсон нягтлан бодогч
Хянасан захирал

Б. Даваасүрэн
Ш.Оюунгэрэл

8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Биелэлтийн хувь	Тайлбар, үндэслэл
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	100%	Үйлдвэрлэлд ажиллах хүчин дутагдал болон борлуулалт муу байснаас төлөвлөгөөт зорилтоо биелүүлж чадаагүй ч хууль журмаар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, техникийн нөхцөл, стандартыг хангаж ажилласан болно.
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	100%	2023 оны Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг биелүүлсэн.
3.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	100%	Дүүргийн хот тохижилттой гэрээ байгуулан 584000 төгрөг төлж 7 хоног бүр хогоо төвлөрсөн цэгт зайлуулж байсан болно.
4.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	100%	Үйлдвэрлэлийн удирдлага зохион байгуулалтын ажлууд бүрэн биелсэн.
5.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, үр дүнгийн хэлэлцүүлгийн тэмдэглэл	100%	2023 оны 10 сарын 15-ны өдрийн компанийн ажилтануудын хурлаар 2023 онд үйлдвэрлэлтийн төлөвлөгөө ажиллах хүчний дутагдлаас болж 33,3% биелүүлсэн бөгөөд холбогдох байгууллагуудтай гэрээ хийж хууль журмаар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт”-ийг хэлэлцэж 100,0% хангалттай биелүүлсэн гэж тэмдэглэсэн.
	ДҮН (арифметикдундаж)	100.0 %	

Хавсралтууд





Нөхөн сэргээлтийн өмнөх байдал



Нөхөн сэргээлт хийж байгаа нь























Иргэдийн төлөөлөл







Эрчим хүчний /баяжуулсан/ нүүрс тээвэрлэх зөвшөөрлийн бичиг

Бичлэг: Дугаар 4640

Сум/ дүүргийн: Аймаг/хотын, Цогцэций, Энержин Ресурс

Уурхайн нэр, олборлогч аж ахуйн нэгжийн нэр, талбайн байршил/гаас эрчим хүчний /баяжуулсан/ нүүрс тээвэрлэх эрх олгов.

Эрчим хүчний /баяжуулсан/ нүүрсний хэмжээ: 30 тн

Бүүлгах байршлын мэдээлэл: Гудамжны Технологийн Уур Угдварлалтын Холбоо, Могойн 3-р хороо Карамжин Худалын ХХК

Тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, зориулалт, даац: АТ-08-4HP, 05-50-PP

Тээвэрлэх, Эхлэх 2023 он, 08 сар 28 өдөр, Дуусах 2023 он, 09 сар 08 өдөр

Хүчинтэй хугацаа: 05-50-PP

Олгосон: 5 хот, аймаг, Цэнгэлтэй сум/дүүрэг-ийн 1-р хороо Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (эрх бүхий байгууллагын нэр, ажилтан) Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга Ш. РАСИМЗА

Гарын үсэг (тэмдэг): Ш.РАСИМЗА

Хүлээн авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын, хаяг, нэр: ӨНӨ 2021 ХӨГӨӨ ТАСХОТ, ХТ-200-1

Гарын үсэг (тэмдэг): Ш.РАСИМЗА

Шалгасан тухай тэмдэглэл

Улаанбаатар хотод орж ирэх тохиолдолд дамжин өнгөрөх, шалган нэвтрүүлэх авто тээврийн хяналтын цэг дэх мэргэжлийн хяналтын болон цагдаагийн албан хаагчдад бүртгүүлж, шалгуулна.

Шалгасан газрын нэр	Он сар өдөр	Шалгасан хяналтын цэгт зөрчилтэй эсэх	Шалгаж бүртгэсэн хүний албан тушаал, овог нэр, гарын үсэг, түүний тайлал, тэмдэг, холбоо барих утас
А. ХХК (Олох байгууллага)	2023.08.28	Үгүй	Д. БУДУУБЕЕГА, 98118580
Б.1.			
Б.2.			
(Цагдаагийн байгууллага)			
В.1. А. Р. З. Х. Х. Х.	2023.08.31	Үгүй	П.Н. БАТ-Т, А. ГАИШБЕЕГА
В.2.			
(Мэргэжлийн хяналтын байгууллага)			
Г.			
(Дамжин өнгөрөх цэгийн бүртгэл)			
Д.			
Хүлээн авагчийн тэмдэглэл			

Хяналтын хэсэг Г

Эрхийн бичиг

(Байгууллагын нэр)

ОгнооТН



ДҮГНЭЛТҮҮД



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ц.Жигжиджавын гудамж-7/1,
Нийслэлийн Засаг захиргааны II байр
Хангарди ордон
Утас: 31-80-03, Факс: (976-11) 32-06-69
<http://www.baigal.ub.gov.mn>

2016.03.29 № 1416
танай _____ -ны № _____ -т

"ХУАЛЯН" ХХКОМПАНИЙ ЗАХИРАЛ
Ш.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

Танай байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг судлан үзэж "Усны тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтыг үндэслэн ус ашиглуулах дүгнэлтийг хавсралтаар хүргүүлж байна.


Хавсралт 2 хуудастай.


Хувийг: Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Татварын хэлтэст

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


Х.МАРАТ

1150590680







НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 2021/19

Улаанбаатар хот

“ХУАЛЯН” ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ш.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар: “Хуалян” ХХК, захирал Ш.Оюунгэрэл, Налайх дүүргийн 3 дугаар хороо, “Хуалян” тоосгоны үйлдвэр, Утас:99115569, 99122910, Улсын бүртгэлийн дугаар 9019047059, Регистрийн дугаар 2718375
2. Төслийн байршил /ХӨ;ЗУ/: Налайх дүүргийн 3 дугаар хороо, “Налайхын зүүн жигүүр” нэртэй газар, 47°44'53"N, 107°17'53"E
3. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт: УСТ-138-86 стандартын шаардлага хангасан 50-125 маркийн тоосго үйлдвэрлэх.
4. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/: Ил уурхайгаас жилд шавар олборлож 3.0 сая.ширхэг тоосго үйлдвэрлэнэ. Өдөрт дунджаар 25.0 мян.ширхэг тоосго хийнэ. Жилд 150 хоног, ажлын 8 цагаар 2 ээлжээр ажиллана. 100 иргэнийг ажлын байраар хангаж ажилладаг.
5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ: Хоногт 25.0 мян.ширхэг тоосго, жилд 2.5-3.0 сая.ширхэг тоосго үйлдвэрлэнэ.
6. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/: 130 метрийн гүн өрмийн худгаас усыг авч ашигладаг бөгөөд ундрага нь 1.3 л/с, ундаргаар тооцож үзэхэд хоногт 112.32 м³ ус авч ашиглах боломжтой. Үйлдвэр ажиллах хугацаанд өдөрт дунджаар 20 м³ ус авч ашигладаг.
7. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/: Ахуйн болон технологийн хэрэгцээнд гаргасан гүний худгаас өөр усны барилга байгууламж байхгүй. Худаг дээр 2.5x2.5 метрийн хэмжээтэй тоосгон байртай. Худгаас усыг ахуйн болон үйлдвэрлэлийн гэсэн хоёр 2 тонны болон 10 тонны ус нөөцлөх саванд нөөцөлж нөөцийн савнаас усыг авч ашигладаг.
8. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /Насосны хүчин чадал, марк/: QS-95 маркийн насосыг 120 м гүнд суурилуулсан. 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр тоолуураа баталгаажуулсан. Тоолуурын заалт 04341 м³;
9. Хэрэглэгчээс гарах хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин: Тоосго үйлдвэрлэхэд шингэн хаягдал гарахгүй бөгөөд ажилтан алба хаагчдаас гарах ахуйн шингэн хаягдлыг доторлосон нүхэн жорлонд хуримтлуулж соруулан бохирын коллекторт нийлүүлдэг.
10. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг “Хань-Өргөө” ХХК-иар хийлгэсэн. Үнэлгээнд заасан зөвлөмжийг мөрдөж ажиллах шаардлагатай.

1150500169

11. **Онцгой нөхцөл:** Үйлчилгээ унд ахуйд зориулан гаргасан гүний худгийг бохирдлоос хамгаалах зорилгоор Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд /хуучин нэрээр/, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаартай тушаалаар батлагдсан "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.18 дахь заалтад заасны дагуу эрүүл ахуйн хориглолтын бүсийг байгуулан мөрдөж ажиллах.

12. **Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг урьдчилсан байдлаар тооцох:** "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай" Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 6, 14 дүгээр хавсралтаар:

- 100 ажилчин өдөрт 180 л ус хэрэглэх бөгөөд жилд 150 хоног ажиллана гэж үзвэл : 100 хүн * 180 л * 150 хоног=2700.0 м³ усыг унд ахуйд;
- 1000 ширхэг тоосго үйлдвэрлэхэд 0.8 м³ ус хэрэглэнэ гэж үзвэл: 3.0 сая.ширхэг тоосго үйлдвэрлэхэд 2400.0 м³ ус ашиглах тооцоо гарч байна.

Нийт: 5100.0 м³

13. **Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:** "Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 302, "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай", "Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн төлбөрийг тооцоход:

1 м³ усны нөөц ашигласны төлбөр: 9440 төг*0.1*20%/100%=188.8 төг

- 9440 -Туул голын сав газарт газрын доорхи ус ашигласан нөхцөлд тооцох 1м³ усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
- 0.1–Туул голын сав газарт, газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр
- 20%- Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолд заасны дагуу Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ

5100.0 м³/жил*188.8 төг=962,880.00 төг /Есөн зуун жаран хоёр мянга, найман зуун наян төгрөг/

2017, 2018, 2019 оны усны төлбөр 1,398,360.00 /нэг сая гурван зуун ерөн найман мянга гурван зуун жаран/ төгрөг төлсөн байна. 2020 онд ажиллаагүй байна.

14. **Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээний талаархи зөвлөмж:**

- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.8-д заасны дагуу Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газраас ус ашиглах зөвшөөрөл, эрхийн бичиг авч, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу усны тоолуурын **04341 м³**-ээс тооцож 2021 оны ус ашиглах гэрээ байгуулах.
- 2021 оны усны нөөц ашигласны төлбөрийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор тоолуурын заалтаар тооцож Налайх дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлэх.
- 3.7. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үйл ажиллагаа явуулах боломжгүй болон тохиолдолд үйл ажиллагаа явуулах хугацааг урьдчилан мэдэгдэж хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг бичгээр гарган нягтлан бодогчид өгнө.
- 3.8. Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэгч байгууллагад шилжүүлнэ.

ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО

4.1. Монгол Улсын “Хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга)” хуулийн 41 дүгээр зүйлийг үндэслэн хог хаягдал гарган төлбөрийг Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19/04 дугаар тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээгээр 100000000 төгрөгийг сар бүрийн өдрийн дотор Хаан банк 5749062084 тоот дансанд аж ахуй нэгжийн нэр, утасны дугаар, хаягийг бичиж хугацаанд бүрэн төлнө.

4.2. Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэх үйлчилгээний хөлс нь хог хаягдлын үйлчилгээний хураамжид хамаарахгүй. Үйлчилгээний хөлсийг гэрээгээр тохиролцсоны дагуу төлнө.

4.3. Төлбөр хураамжид өөрчлөлт орсон тохиолдолд тухайн гэрээнд өөрчлөлт хийнэ.

ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

5.1. Талууд гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр дүгнэж, цаашид илүү үр дүнтэй хамтран ажиллах боломжийг тодорхойлж тооцоо нийлнэ.

5.2. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол Хог хаягдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

ЗУРГАА. ДАВТАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1. Энэхүү гэрээг гүйцэтгэх нөлөөлөх давтагдашгүй хүчин зүйлийн нөхцөл / үер ус, газар хөдлөлт, гал түймэр, нийтийг хамарсан үймээн самуун гэх мэт онц байдлын нөхцөлүүд / үүсэн тохиолдолд талууд гэрээний үүргээсээ татгалзах эрхтэй ба гэрээний талууд учирсан хохирлыг төлөхийг шаардах эрхгүй.

ДОЛОО. БУСАД

7.1. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

7.2. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь талуудын эрх тэгш байдал болон гэрээний чөлөөт байдлын зарчим дээр харилцан тохиролцсоны үндсэн дээр хийгдэнэ.

7.3. Энэхүү гэрээ нь Монгол хэлээр 2 ижил хувь хийгдэх бөгөөд нэг хувийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөгөө хувийг Налайх Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ тус тус хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Тээвэрлэгчийг төлөөлж:

Налайх “Тохижилт Үйлчилгээ”
ОНӨААТҮГ-ыг *Б.Сүхбаатар* ажилтай
Б.Сүхбаатар
Утасны дугаар : _____

Тээвэрлүүлэгчийг төлөөлж”

Хуучин ХХК-ий
З.Сүхбаатар ажилтай
М.О.Оюун
Утасны дугаар : _____

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023 оны 05 дугаар сарын 10

Дугаар 2023/10

Налайх дүүрэг

Нэг. Ерөнхий зүйл

Налайх дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ус ашиглах зөвшөөрөл олгох туай А/38 дугаар захирамж, Нийслэлийн Байгаль орчны газрын даргын олгосон 2023 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн 2023/18 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн: **Ус ашиглуулагчийг төлөөлж:** Налайх дүүргийн Засаг даргын орлогч Н.Мандуул, **Ус ашиглагчийг төлөөлж:** Нийслэлийн Налайх дүүрэг 3 дугаар хороо, 9019047059 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 2718375 регистрийн дугаартай “Хуа Лян” ХХК-ийг төлөөлж захирал Ш.Оюунгэрэл нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийг дуустал 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл:

2.1. **Ус ашиглах зориулалт:** Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар гүний худгаас усыг авч ашиглана.

2.2. **Ашиглах усны хэмжээ:**

2.2.1. **Унд- ахуй, м³/жил** 2700.0 м³

2.2.2. **Үйлдвэрлэл, үйлчилгээ м³/ жил** 2400.0 м³

2.2.3. **Зүлэг талбайн усалгаа м³/ жил**

2.2.4. **эмчилгээ, сувилгаа, хүн/ хоног**

2.3. **Усны чанар, найрлага:**

2.4. **Усны эх үүсвэрийн :**

Байршил: Налайх дүүрэг 3 дугаар хороо Налайхын зүүн жигүүр

Солбилцол: 47°44'53"N, 107°17'53"E

Барилга байгууламж: Унд ахуйн болон технологийн хэрэгцээнд гаргасан гүний худгаас өөр усны барилга байгууламж байхгүй. Худаг дээр 2,5*2,5 метрийн хэмжээтэй тоосгон байртай. Худгаас усыг ахуйн болон үйлдвэрлэлийн гэсэн хоёр 2 тонны болон 10 тонны ус нөөцлөх саванд нөөцөлж нөөцийн савнаас усыг авч ашигладаг.

Тонго төхөөрөмжийн нэр, марк: QS-95 маркийн насосыг 120 м гүнд суурилуулсан. 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр тоолуураа баталгаажуулсан. Тоолуурын заалт 04342 м3.

Хүчин чадал: 130 метрийн гүн өрмийн худгаас усыг авч ашигладаг бөгөөд ундарга нь 1.3 л/с, ундаргаар тооцож үзэхэд хоногт 112.32 м3 ус авч ашиглах боломжтой. Үйлдвэр ажиллах хугацаанд өдөрт дунджаар 20м3 ус авч ашигладаг.

2.5. **Хаягдал усны:**

Хэмжээ:

Стандартын шаардлага:

Хаях цэгийн байршил: Тоосго үйлдвэрлэхэд шингэн хаягдал гарахгүй бөгөөд ажилтан алба хаагчдаас гарах ахуйн шингэн хаягдлыг доторлосон нүхэн жорлонд хуримтлуулж соруулан бохирын коллекторт нийлүүлдэг.

Солбилцол: 47°44'53"N, 107°17'53"E

2.6. **Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ.** Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг

Органик бодис, кг

Эрдэс бодис, кг

Хүнд метал, кг

Аюултай бохирдуулах бодис, бодис, гр

2.7 Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсэн үнэлгээг “Хань-Өргөө” ХХК-иар хийлгэсэн.

2.9. Усны тоолуурын төрөл нэр дугаар:

Төрөл, нэр, дугаар:

Загвар

Тоолуурын тоо:

Суурилуулсан байгууллага, огноо:

Тоолуурын заалт:

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: 2023 оны ус ашиглах дүгнэлтээр үйлчилгээний ус ашиглалтад 5100.0 м³ ус, автоклавт ус ашиглах тооцоо гарсан бөгөөд усны төлбөрийг “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын засгийн газрын 327 дугаар тогтоолын дагуу усны төлбөрийг усны тоолуурын заалтаар 2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор Налайх дүүргийн Татварын хэлтсийн Хаан банкны 5749922224 дугаартай дансанд төвлөрүүлнэ.

2.11. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2 аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Налайх дүүргийн
Засаг даргын орлогч
Н.Мандуул

2023 оны 05 сарын 15

Ус ашиглагчийг төлөөлж:

“Хуалян” ХХК-ийн
захирал
Ц.Оюунгэрэл

2023 оны 05 сарын 11

БАТЛАВ.
НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ
Н.МАНДУУЛ
2023 оны 05 дугаар сарын 15

БАТЛАВ.
“ХУАЛЯН” ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ш.ОЮУНГЭРЭЛ
2023 оны 05 дугаар сарын 11

**ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ
БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ**

2023 оны 05 дугаар сарын 10 өдөр

№04

Налайх дүүрэг

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Туул голын сав газрын захиргааны гаргасан 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 32 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн Нэг талаас: Ус ашиглуулагчийг төлөөлж дүүргийн Засаг даргын орлогч Н.Мандуул, нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3 дугаар хороо байрлах 9019047059 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 2718375 тоот регистрийн дугаартай “Хуалян” ХХК-ийг төлөөлж захирал Ш.Оюунгэрэл нар ус бохирдуулсаны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1/нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар. Хаягдал ус Ерөнхий шаардлага” MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр,
2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ,

2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ,
2.4.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн,

2.4.5. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.
Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, мэргэжил аргагүйн удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалтад заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх

“Налайхын уурхайн зүүн жигүүр” шаврын ордын 2023 оны Байгаль Орчны Менежментийн тайлан

заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно.

3.3. Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа болон дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм, норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзэлхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл /тоолуур/-ийг “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхэд эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

Гэрээ байгуулсан:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
..... /Ц.Тунгалаг/

Хаяг: УБ, Налайх дүүрэг, 2 дугаар хороо,

Утас: 7023-2419 17147349

Ус бохирдуулагчийг төлөөлж:

“Хуалян” ХХК-ийн ажилтан..... /Хуалян/

Хаяг: Хуалян х. н. Увс сум, Хуалян

Утас: 99115569 /Тогтоолын үндэс/

“Налайхын уурхайн зүүн жигүүр” шаврын ордын 2023 оны Байгаль Орчны Менежментийн тайлан

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 11

Налайх дүүрэг

Гэрээний зорилго: Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад “Хөдөлмөрийн тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Хог хаягдлын тухай”, “Зөрчлийн тухай” “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль холбогдох дүрэм, журам, дүүргийн удирдлагаас гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, төр захиргааны эрх бүхий байгууллагаас дэмжлэг үзүүлэн, хяналт тавих, нөгөө талаас сайн дурын үндсэн дээр орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийн хүрээнд нийгмийн хариуцлагыг тодорхойлж, хамтран ажиллахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Нэг. Ерөнхий зүйл

Нэг талаас Дүүргийн удирдлагыг төлөөлж Налайх дүүргийн Засаг даргын орлогч Н.Мандуул (цаашид “Захиргааны байгууллага” гэх), нөгөө талаас Аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж Налайх дүүргийн хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 2718375 регистрийн дугаартай, “Хуя Пян” ХХК-ийн захирал Ш.Оюунгэрэл (цаашид “ААН, байгууллага” гэх) нар нь хамтран дараах нөхцөлүүдийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

1.1. Талууд бие биенийхээ үйл ажиллагааг харилцан хүндэтгэж, гэрээний заалтуудыг чанд мөрдөнө.

1.2. Гэрээг 2% үйлдэж, хоёр тал харилцан тохиролцон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талуудад гэрээний 1 хувийг хадгалуулна.

1.3. Гэрээ нь 2023 оны 05-р сарын 15-ний өдрөөс 2024 оны 05-р сарын 10-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

1.4. Аль нэг талын санаачилгаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

2.1. Хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлнэ.

2.2. Газар ашиглах, эзэмших, ашигт малтмал эрх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжинд заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах.

2.3. Захиргааны байгууллага нь гэрээний хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн аливаа үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд тухай бүр нь үнэн зөв мэдээлж ажиллах.

2.4. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч сургалт, семинар, үзэсгэлэн худалдаа болон бусад арга хэмжээнд оролцуулах ажлыг зохион байгуулах.

Гурав. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

3.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг чанд биелүүлж, олон нийтийг хамарсан арга хэмжээ болон нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхи санаачлагатай оролцох

3.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь орчны 50м хүртэлх газрын ашиглалт хамгаалалт, цэвэрлэгээ, халтиргаа, гулгааг хариуцан тогтмол цэвэрлэх, мод, бут, зүлэг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны тохижилтод хувь нэмрээ оруулж, гаднах хаягаа гэрэлтдэг, товгор крилл үсгээр бичиж байршуулах, гэрэлтүүлгийг стандартын дагуу хийж гүйцэтгэх, хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах

3.3. Нийслэлийн агаарын бохирдлыг багасгах зорилтын хүрээнд өвлийн улиралд сэргээгдэх эрчим хүчний бие даасан үүсгүүр, стандартын шаардлага хангасан хийн болон цахилгаан халаагуур, бүрэн шаталттай шахмал түлш ашиглах

3.4. Зориулалтын (2-3 хоногийн багтаамжтай) хогийн савтай байж, бохир усны цооног, бие засах газрыг стандартын шаардлага хангасан хөрс бохирдуулахгүй байдлаар шийдэх

3.5. Орон нутгийн нийгмийн халамж дэмжлэг шаардлагатай өрх, иргэдэд чиглэсэн тодорхой үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх

3.6. Дүүрэгт ажлын байрыг нэмэгдүүлж, ажиллах хүчний 80 хүртэлх хувьд дүүргийн харьяалалтай иргэдийг хамруулж, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулан, чадваржуулах ажлыг зохион байгуулж, ажиллагсдын хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл болон, тухайн дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, ажлын байран дахь аюул

“Налайхын уурхайн зүүн жигүүр” шаврын ордын 2023 оны Байгаль Орчны Менежментийн тайлан

эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилтантай мэдээлэл солилцож, хамтран ажиллах

3.8. Ажилчдыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хуулийн дагуу цаг хугацаанд нь хамруулах

3.9. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. /Хөдөлмөрийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №36 дугаар тушаалаар батлагдсан/

3.10. Ойн тухай хууль, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аж ахуйн нэгжийн эзэмшлийн хашаанд жилд дунджаар ширхэг мод тарьж, дүүргийн ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэх.

Дөрөв. Гэрээ дуусгавар болох

Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:

4.1. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаар аль нэг тал нөгөө талдаа бичгээр мэдэгдсэн боловч нөгөө тал нь ажлын 14 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй эсхүл хариу өгөөгүй тохиолдолд;

4.2. Гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон.

4.3. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг сунгахгүй.

4.4. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг, халдварт өвчний тархалт, дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, нийтийг хамарсан ажил хаялт, эрх бүхий байгууллагаас гаргасан хорио цээр гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцно.

Тав. Нэмэлт нөхцөл

Гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон.
Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг сунгахгүй.
Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг, халдварт өвчний тархалт, дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, нийтийг хамарсан ажил хаялт, эрх бүхий байгууллагаас гаргасан хорио цээр гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцно.

Зургаа. Гэрээний хариуцлага, дүгнэх

6.1. Талууд гэрээний биелэлтэд тавих хяналтыг хамтран хийж, оны эцэст үр дүнг тооцож гэрээг дүгнэнэ.

6.2. Дүүргийн ойн арга хэмжээ болон дүүргийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын ажлуудыг талууд харилцан зөвшилцөж, тухай бүрт нь шийдвэрлэн хамтран ажиллана.

6.3. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол Улсын “Зөрчлийн тухай”, “Хог хаягдлын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай” болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.4. Холбогдох хууль тогтоомж, стандарт, гэрээгээр хүлээсэн үүргээ давтан зөрчсөн, иргэдийн эрх ашгийг ноцтой хохироосон нь тогтоогдсон нөхцөлд аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг холбогдох хуулийн байгууллагатай хамтран бүрэн зогсоох арга хэмжээ авна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ДҮҮРГИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
..... Н.МАНДУУЛ
2023 оны 05 сарын 15 өдөр
УТАС:
ХҮНС, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ТУНГАЛАГ
2023 оны 05 сарын 15 өдөр
УТАС: 70232419

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ
ТӨЛӨӨЛЖ:
“.....” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
1.....
2023 оны 05 сарын 15 өдөр
УТАС:
“.....” ХХК-ИЙН
АЖИЛТАЙ
1.....
2023 оны 05 сарын 15 өдөр
УТАС: 99115569

2.3. Газрын төлбөрийг нэхэмжлэхийн дагуу Татварын албанд тушаана. Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

2.4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ болон уулын ажлын төлөвлөгөөнд өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг 30 хоногийн дотор шинэчлэн ногдуулна.

Гурав. Газар ашиглуулагчийн хүлээх эрх, үүрэг, хариуцлага

3.1. Газар ашиглагч газрыг гэрээний нөхцөл, зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих;

3.2. Газрыг гэрээний нөхцөл, зориулалтын дагуу ашиглаагүй, энэ талаар тавьсан шаардлага болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон, тусгай зөвшөөрөл цуцлагдсан, дуусгавар болсон тохиолдолд гэрээ цуцалж, Газрын тухай хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

3.3. Газар ашиглах гэрээг жил бүр дүгнэх;

3.4. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх үүрэг.

Дөрөв. Газар ашиглагчийн хүлээх эрх, үүрэг, хариуцлага

4.1. Газрыг гэрээний нөхцөл, зориулалтын дагуу ашиглах;

4.2. Газар ашиглалтын төлбөрийг хугацаанд нь үйл ажиллагааны үр дүн гарахыг хүлээлгүй төлнө;

4.3. Газрын төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй төлбөрийн дүнгээс бодож хоног тутам 0,3 хувийн алданги төлнө;

4.4. Өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах;

4.5. Газар ашиглах гэрээг жил бүр дүгнүүлэх;

4.6. Газар ашиглагч нь уг газрыг ашиглахтай холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээг хугацаанд нь биелүүлэхийн зэрэгцээ, хот нийтийн аж ахуйг арчлан хамгаалах, засаж тохижуулах үүрэгтэй;

4.7. Газрын тухай хууль тогтоомж, газар ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол гэрээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар гэрээний хугацааг сунгуулах;

4.8. Газар, байгаль орчныг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах тухай хууль, тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;

4.9. Газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

4.10. Бусдын газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;

4.11. Орчны газарт байрлаж байгаа инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ эрхэлж байгаа мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

4.12. Гэрээнд зааснаас өөр зориулалтаар газрыг ашигласан бол газар ашиглуулагч гэрээг цуцалж, ашиглалтын явцад учирсан хохирлыг нөхөн төлөх;

4.13. Газар ашиглагч нь албан ёсны хааг, утасны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 3 хоногийн дотор газар ашиглуулагч талд мэдэгдэж, гэрээнд тусгуулна.

4.14. Газар ашиглагч нь Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6-д заасны дагуу уурхайн эдэлбэр газрынхаа 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана;

4.15. Газар ашиглагчийн хүлээх эрх, үүрэг, хариуцлага;

4.16. Холбогдох хууль, тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг.

Тав. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

5.1. Газар ашиглах эрхийг захиргааны журмаар дуусгавар болгосон тохиолдолд уг газрыг эргүүлэн хүлээлгэн өгөх асуудлыг газар ашиглагч бүрэн хариуцна.

5.2. Газар ашиглагчийн өмчлөлд байгаа газраас салгаж болохгүй барилга байгууламж эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл газар ашиглах эрхийг дуусгавар болгож шийдвэрлэнэ.

“Налайхын уурхайн зүүн жигүүр” шаврын ордын 2023 оны Байгаль Орчны Менежментийн тайлан

Нэгж талбарын дугаар:



ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АЖ АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2023 оны 5 сарын 22 өдөр

№ 01114-2023/00992

Улаанбаатар хот

Монгол Улсын Газрын тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2007 оны 01 сарын 29-ны өдрийн 01113-А/4508/2007 тоот шийдвэрийг үндэслэн газар ашиглуулагчийг төлөөлж, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтэн Балжинням овогтой Янжинбилэг, газар ашиглагчийг төлөөлж

Хуалян ХХК-ний Захирал
(иргэн, аж ахуйн нэгжийн нэр)
Шагдар овогтой Оюунгэрэл

нар энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын / Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2007 оны 01 сарын 29-ны өдрийн 01113-А/4508/2007 тоот шийдвэр энэхүү газар ашиглуулах гэрээ байгуулах үндэслэл болно.

1.2. Гэрээнд дараах зүйлийг заавал тусгана.

1.2.1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг харуулсан зураг схем.

1.2.2. Газар ашиглуулагчаас газар ашиглагчид уг газрыг хүлээлгэн өгсөн акт.

1.2.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28-р тогтоолоор баталсан журмын дагуу хийлгүүлж баталгаажуулна.

1.2.4. Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт.

1.3. Энэхүү гэрээний 1.2.-т заасан бүрдүүлбэр нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд түүнийг бүрдүүлж хийгээгүй тохиолдолд уг гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Ашиглалтад олгосон газрын нийт хэмжээ

289382

Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг ашиглах зориулалт

Тухайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ

Уурхайн газар

289382

Уурхайн ашиглалт, олборлолт явуулж буй талбай

2478

Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн талбай

7780

Нөөц газрын талбай

279124

Газар ашиглах хугацаа

15

2.2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний 2 дугаар хавсралтад заасан тусгай зөвшөөрлийн талбайн солбилцол бүхий кадастрын зураг нь гэрээний хавсралт болно. Тус солбилцлын дагуу тухайн газрын байрлал, хилийн заагийг тогтооно.

“Налайхын уурхайн зүүн жигүүр” шаврын ордын 2023 оны Байгаль Орчны Менежментийн тайлан

5.3. Газар ашиглах эрх, гэрээний хугацаа дуусгавар болоход тухайн газар дээрх барилга байгууламж бусад эд хөрөнгийг хэрхэх тухай анх эрх олгосон шийдвэрт заасан бол энэ дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Гэрээний нөхцөл

6.1. Энэхүү гэрээг талууд гарын үсэг зуран баталгаажуулснаар тухайн жилдээ хүчинтэй. Талууд жил бүр гэрээний биелэлтийг дүгнэж, харилцан тооцоо хийнэ. Гэрээний биелэлтийг дүгнэхдээ хоёр тал протокол үйлдэнэ.

6.2. Протокол нь энэхүү гэрээний нэгэн адил хуулийн хүчинтэй байх ба гэрээний салшгүй хэсэг байна.

6.3. Гэрээ байгуулагч талууд үндэслэлтэй гэж үзвэл уг гэрээг хэдийд ч дуусгавар болгох эрхтэй боловч нөгөө талдаа **30 хоногийн** өмнө мэдэгдэх үүрэгтэй.

6.4. Гэрээний аль ч тал нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай 14 хоногийн өмнө бичгээр тохиролцоно.

Долоо. Бусад

7.1. Газар ашиглагч Монгол Улсын Газрын тухай хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг болон газар ашиглуулах энэхүү гэрээний нөхцөл болзлыг биелүүлээгүй, ноцтой зөрчсөн бол гэрээг цуцалж газар ашиглах эрхийг дуусгавар болгоно.

7.2. Энэхүү гэрээтэй холбогдсон маргааныг хэлэлцээрийн журмаар зохицуулна. Хэрэв хэлэлцээрт хүрэхгүй бол Монгол Улсын үндсэн хууль тогтоомжын дагуу шийдвэрлүүлнэ.

7.3. Уг гэрээг Монгол хэл дээр тус бүр 3 хувь үйлдэв. Хувь тус бүр нь нэгэн адил хүчинтэй байна.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Газар ашиглуулагч:

Нийслэлийн газар зохион байгуулалтын алба

Наадамчдын зам 1200, Арцатын ам, 4 дүгээр хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100

Утас:11315712

Газар ашиглагч: **Хуалян ХХК**

Газрын байршил: **Улаанбаатар, Налайх, 3-р хороо, Налайхын зүүн жигүүр**

Газар эзэмшигчийн хаяг:

Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар: /2718375/

Банк, дансны дугаар:

Харилцах утас: **99115569**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар эзэмшүүлэгчийг төлөөлж:

Газар эзэмшигчийг төлөөлж:

Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга

Ганболд овогтой Батзориг

.....тамга

Ашигт малтмал, эдлэлээр газар хариуцсан нэргэжилтэн

Балжинням овогтой Янжинбилэг

гарын үсэг /...../

Хуалян ХХК-ны Захирал

Ш.Оюунгэрэл

Гарын үсэг /...../ тамга/

Энэхүү гэрээний нэг хувийг **1260510346** дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

МИДЛИНГ (БАЯЖУУЛСАН НҮҮРС-MNS 6457:200014) ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр.

№ 23/20

Улаанбаатар хот

Энэхүү Нүүрс худалдах, худалдан авах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлүүдийг үндэслэн, нэг талаас “Шинэ Уянга” ХХК /РД:5565057/-ийг төлөөлөн Захирал ажилтай Дашдондог овогтой Энхтүвшин (цаашид Худалдагч гэх) нөгөө талаас Түвшин ХХК /РД: 2718325 /-ийг төлөөлөн Дашдорж ажилтай У.Оржтүвшин (цаашид Худалдан авагч гэх) дараах зүйлсийг гхарилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Худалдагч нь гэрээнд заасан шаардлага хангасан нүүрс (цаашид “Бараа бүтээгдэхүүн” гэх)-ийг чанар, стандартын дагуу нийлүүлэх, Худалдан авагч тал нь нүүрсийг худалдан авахтай холбоотой талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох мөн харилцааг зохицуулахад гэрээний зорилго оршино.
- 1.2. Худалдагч нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62-р тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” А/1377 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Уур үйлдвэрлэгчдийн технологийн зуухуудад сайжруулсан түлш хэрэглэх бодит судалгааг МБМ Үйлдвэрлэгчдийн холбоо, ШУТИС-ийн эрдэмтэн багш нар хийсний үр дүнгээр хийн зууханд мидлинг (5000 ккал дээш) хэрэглүүлэхийг үүрэг болгосны дагуу худалдан авагч талд дээрх шаардлага хангасан() тонн нүүрсийг нийлүүлнэ.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Энэхүү гэрээ нь талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 2.2. Гэрээний хугацаа нь гэрээ хүчин төгөлдөр болж баталгаажсанаас хойш 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 2.3. Талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгах буюу гэрээнд нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах бөгөөд гарын үсэг зурж, тамга дарснаар энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

- 2.4. Гэрээний хугацаа дуусхад талуудын аль аль нь гэрээг цуцлах санал гаргаагүй, талууд өөрсдийн харилцааг үргэлжлүүлсэн нөхцөлд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ТООЦОО

- 3.1 Худалдагч нь худалдан авагчийн өгсөн захиалгын дагуу нүүрсийг нийлүүлэх бөгөөд 1 тн нүүрсний үнэ *220,000... / Төгрөг дээр дсгагч мөхөм /* төгрөг байна. Энэхүү үнийн дүнд /НӨАТ орсон болно/.
- 3.2 Нүүрс худалдан авах захиалга өгөхдөө тоо хэмжээг худалдан авагч тал тодорхой зааж өгөх ба нэг удаагийн тээврийн ачааны доод хэмжээ... тонн байна.
- 3.3 Худалдан авагч нь нүүрс хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор хүлээн авсан тоо хэмжээгээр худалдагч талд нүүрсний үнийг “Шинэ Уянга” ХХК-ний “Хас” банкны 5000486907, ХААН банкны 51 23088 538 тоот дансанд шилжүүлж төлнө.
- 3.4 Гэрээний хүчинтэй хугацаанд хэрэв ачаа барааны тээврийн үнэ, дизель түлш, барааны үндсэн үнэ зэрэг гэрээг анх байгуулсан үеэс 15 хувь болон түүнээс дээш хэмжээгээр нэмэгдсэн нөхцөлд талууд харилцан тохиролцож гэрээний үнэ буюу төлбөрийг шинэчлэн тогтооно.
- 3.5 Энэхүү гэрээний 3.4 дэх хэсэг заасан үндэслэлээр гэрээний үнэ өөрчлөгдөх нөхцөл байдал үүссэн боловч талууд харилцан тохиролцож чадаагүй бол барааны үнэ, тээврийн үнэ, дизель түлшний үнийн нэмэгдсэн хувь хэмжээгээр гэрээний төлбөр нэмэгдсэнд тооцно.

ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Худалдан авагч тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Худалдагчаас шаардах эрхтэй.
- 4.2 Худалдан авагч тал нь захиалга өгсөнөөс хойш гэрээнд заасан хугацаанд нүүрсээ талбай дээр буулгахыг худалдагч талаас шаардах эрхтэй.
- 4.3 Нүүрсний чанар стандарт тоо хэмжээнд хяналт тавьж шаардлагад нийцсэн эсэхийг шалгах эрхтэй.
- 4.4 Худалдан авагч тал бүтээгдэхүүн хүлээн авах хугацаагаа графикаар худалдагч талд гаргаж өгөх үүрэгтэй.
- 4.5 Худалдан авагч нь барааг хүлээн авч, буулгах талбайг бэлэн байлгах, ачааг саадгүй буулгах нөхцлөөр хангах үүрэгтэй.
- 4.6 Барааг буулгах үйл ажиллагааг бүрэн хариуцаж түргэн, шуурхай хүлээн авч, тээврийн машиныг чөлөөлөх үүрэгтэй.
- 4.7 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хугацаандаа бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.

- 4.8 Нүүрсийг талбайд буулгах үед хүлээлцэх акт үйлдэж, барааны чанарт шалгалт хийж хүлээн авах үүрэгтэй.
- 4.9 Худалдан авагч нүүрсийг хүлээн авсныг гэрчлэх тодорхой үйлдэл хийсэн бол түүнийг хүлээн авсанд тооцно.
- 4.10 Худалдан авагч тал нүүрсний захиалгыг 7-10 хоногийн өмнө худалдагч талд мэдэгдэх үүрэгтэй.

ТАВ. ХУДАЛДАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Худалдан авагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 5.2 Нүүрсийг тээврийн хэрэгслийн өөрийн батлагдсан даацад үндэслэн ачих эрхтэй.
- 5.3 Гэрээний төлбөрийг хугацаандаа бүрэн төлөхийг шаардах эрхтэй.
- 5.4 Худалдагч тал нь гэрээнд заасан мидлинг нийлүүлж, худалдан авагч талд бараа материалын зарлагын баримтаар хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 5.5 Худалдагч тал нь Худалдан авагч талын захиалсан бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийг бүрэн хариуцаж худалдан авагч талын талбай дээр буулгах үүрэгтэй.
- 5.6 Худалдагч нь Худалдан авагч талын бараа бүтээгдэхүүнийг захиалгын дагуу тогтоосон хугацаанд түргэн шуурхай тасралтгүй нийлүүлэх үүрэгтэй.
- 5.7 Худалдагч нь бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх хуваарь өгснөөс хойш календарын 5-7 хоногийн дотор нийлүүлнэ.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 6.1 Гэрээний талууд гэрээний үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талд учирсан шууд болон шууд бус хохирол, гомдлыг барагдуулна.
- 6.2 Худалдан авагч нь төлбөрийг гэрээгээр тохиролцсон хугацаанд төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3%-иар тооцож хоног тутамд алданги төлнө.
- 6.3 Худалдагч тал нь бараа бүтээгдэхүүний захиалгыг тогтоосон хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.3%-иар тооцож хоног тутамд алданги төлнө.
- 6.4 Гэрээний талууд хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас аль нэг талд хохирол учирсан тохиолдолд уг хохирлыг гэм буруутай тал нь хохирлыг бүрэн хариуцаж, арилгах үүрэгтэй.
- 6.5 Хэрэв худалдан авагч талын захиалсан нүүрсийг худалдагч тал тээвэрлэн заасан газарт хүргэсэн боловч худалдан авагч тал нүүрсийг хүлээн аваагүй нөхцөлд ачаа тээврийн зардал, хадаглалтын зардлыг худалдагч талд бүрэн төлж барагдуулна.

ДОЛОО. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1 Гэнэтийн, давагдашгүй хүчин зүйлийн улмаас худалдан авагч тал болон худалдагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийж гүйцэтгээгүй бол шаардлагатай хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг сунгаж болно.
- 7.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлд гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер зэрэг байгалийн гамшиг, хорио цээр гэх мэт талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.
- 7.3 Худалдан авагч тал захиалга өгсөн боловч хил хаах, ачаа тээврийг зогсоох, бүх нийтийг хамарсан хөл хорио, үйлдвэрлэгчээс нүүрс нийлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн нөхцөлд уг хугацаанд худалдагч талыг гэрээний хугацааг хэтрүүлсэн хэмээн үзэхгүй.
- 7.4 Нүүрс хүлээлгэн өгсөнөөс хойш давагдашгүй хүчин (хөл хорио тогтоох, онц байдал зарлах, байгалийн гамшиг гэх мэт) зүйл тохиолдвол үүнийг төлбөр төлөхгүй байх нөхцөл гэж үзэхгүй.

НАЙМ. НУУЦ ХАДГАЛАХ БА БАТАЛГАА

- 8.1 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцал хамаарах аливаа мэдээ мэдээллийг бусдад бичгэн буюу аман хэлбэрээр задруулах, гэрээнд зааснаас өөр зорилгоор ашиглах эрхгүй.
- 8.2 Нууц хадгалахтай холбоотой үүргээ зөрчсөн тал нөгөө талдаа учруулсан хохирлыг бүрэн хариуцна.
- 8.3 Энэ заалт нь бараа нийлүүлэлтийн бүх ажилтан, төлөөлөгчид болон туслан гүйцэтгэгч /хэрэв байгаа бол/ нарт нэгэн адил хамаарна.

ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ

- 9.1 Талууд харилцан тохиролцож гэрээг цуцалж болно.
- 9.2 Аль нэг тал гэрээг дангаар цуцлах хүсэлт гаргах эрхтэй бөгөөд энэ хүсэлтээ 14-өөс доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэх бөгөөд албан бичигт гэрээг цуцлах шалтгаан, нөхцлийг дэлгэрэнгүй тусгасан байна.
- 9.3 Гэрээний нөхцлүүд бүрэн биелэгдсэнээр гэрээний хугацаа дуусч 2 тал гэрээг сунгаагүй тохиолд гэрээг дуусгавар болсонд тооцно.

АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 10.1 Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал, зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.

10.2 Маргаан болон зөрөлдөөнийг зөвшилцөх аргаар шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

- 11.1 Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.
- 11.2 Энэхүү гэрээ талуудын эрх ашиг, сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.
- 11.3 Гэрээний аль нэг талын хүсэлтээр гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр гэрээнд бичгээр нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 11.4 Талуудын Үүсгэн байгуулагчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, бусад өмчлөгчид өөрчлөгдсөнөөс үл хамааран гэрээ хүчин төгөлдөр байна.
- 11.5 Монгол Улсын эрх бүхий төрийн байгууллагаас холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан, нэмэлт тайлбар хийсэн, тухайн орд газраас борлуулах нүүрсний үнийг шинэчлэн тогтоосон, нүүрсний татвар хураамжийг нэмэгдүүлсэн, дотоодын зах зээл дэх шатахууны үнэ, нүүрсний үнийн хэлбэлзэл зэрэг хүчин зүйлээс хамаарч талууд тохиролцон гэрээний үнэнд өөрчлөлт оруулна.
- 11.6 Гэрээг монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.
- 11.7 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Шинэ-Уянга ХХК-ны Захирал
..... Д.Энхтүвшин

Хаяг: БГД, 6-р хороо, 46-23 тоот

Утас: 99118299, 94948299, 99074688



ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХХК-ны Захирагч

Хаяг: Налайх / 3-р хороо

Хуалян ХХК-н төлөөлөгч

Утас: 99115569